



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл
бүхий хөдөлмөрийн гэрээний
биелэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 2.5, 2.7 дахь хэсэг, 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/823 тоот удирдамжийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатартай байгуулсан 2024 оны онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг нийт 99 оноо буюу “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг холбогдох бусад материалын хамт 2025 оны 03 дугаар сарын 25-ны дотор Эрчим хүчний яаманд хүргүүлэхийг гүйцэтгэх захирал /Л.Эрхбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И.ЛУВСАНЦЭРЭН

1701040030



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны
тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дүрмийн 7.3.12 дахь хэсэг, Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/823 тоот удирдамжийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланд өгсөн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /И.Лувсанцэрэн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И.ЛУВСАНЦЭРЭН

1701040040



**ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн
тайлангийн тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, 96 дугаар зүйлийн 96.5, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дүрмийн 7.3.12 дахь хэсэг, Компанийн 2024 оны санхүүгийн тайлан тэнцлийн тухай Үндэсний аудитын газрын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 07/1034 тоот аудитын гэрчилгээ, Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/823 тоот удирдамжийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь 2024 онд 187,521,939,274.00 (Нэг зуун наян долоон тэрбум таван зуун хорин нэгэн сая есөн зуун гучин есөн мянга хоёр зуун далан дөрвөн) төгрөгийн орлого олж 186,543,840,700.00 (Нэг зуун наян зургаан тэрбум таван зуун дөчин гурван сая найман зуун дөчин мянга долоон зуун) төгрөгийн зардалтай, 875,783,529.00 (Найман зуун далан таван сая долоон зуун наян гурван мянга таван зуун хорин есөн) төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, санхүүгийн хөндлөнгийн аудитаар “Өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэн тул компанийн 2024 оны санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /И.Лувсанцэрэн/-д даалгасугай.

3. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах, гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр холбогдох байгууллага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал /Л.Эрхбаатар/-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И.ЛУВСАНЦЭРЭН

1701040035



**ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.6, 80 дугаар зүйлийн 80.2 “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/823 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаар 875,783,529.61 (найман зуун далан таван сая долоон зуун наян гурван мянга таван зуун хорин есөн төгрөг жаран нэгэн мөнгө) төгрөгийн ашигтай ажилласан хэдий ч компанийн тухай хуулийн 47.1.1 дэх хэсэг дэхь “ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх” гэсэн заалттай нийцэхгүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Компанийн 2024 оны ногдол ашиг хуваарилахгүй асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /И.Лувсанцэрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И.ЛУВСАНЦЭРЭН

1701040043